



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

Тогтоол, тогтоолын хавсралтад
нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12, 6.2.8, 8 дугаар зүйлийн 8.2, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 78 дугаар тогтоолын 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмсүгэй:

1/“1.7.1.Сэндбоксын алба”

2/“1.14.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хэлтэс”

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 78 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан Санхүүгийн зохицуулах хорооны бүтэц, зохион байгуулалтын “Ажлын алба” гэсний доор “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хэлтэс” гэж, “Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар” гэсний доор “Сэндбоксын алба” гэж тус тус нэмсүгэй.


3. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 78 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны бүтэц, чиг үүрэгт 6.6.11, 6.6.12, 6.6.13, 6.6.14, 6.6.15, 6.6.16 дахь заалт болон “7.3.Сэндбоксын алба”, “14.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хэлтэс”-ийн чиг үүргийг хавсралтад заасны дагуу тус тус нэмсүгэй.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Ажлын албаны бүтэц, орон тоог шинэчлэн зохион байгуулж, тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН



1/ “6.6.11.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч болон түүний санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн үйл ажиллагаанд зайны хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлэх, ирүүлсэн тайлан, мэдээг хянах явцад илэрсэн зөрчил, дутагдлыг хууль тогтоомжид заасан бүрэн эрхийнхээ хүрээнд арилгуулах арга хэмжээг тухай бүр авах, шаардлагатай гэж үзвэл газар дээр нь шалгах;

6.6.12.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч болон түүний санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг хийж, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид арга хэмжээний болон үйл ажиллагааг хязгаарлах, түр зогсоох, бүртгэлээс хасах саналыг боловсруулан Хорооны удирдлагад танилцуулан шийдвэрлүүлэх;

6.6.13.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч болон түүний санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн үйл ажиллагаа нь хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актад нийцэж байгаа эсэх, тэдгээрийн санхүү, төлбөрийн чадвартай холбоотой үзүүлэлт болон бусад холбогдох тайлан, мэдээ, судалгааг гаргуулан авч, үнэн зөв эсэхийг нь шалган, шаардлагатай тохиолдолд тохируулга, залруулга хийж, холбогдох дүгнэлт гаргах;

6.6.14.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулах, чадавхжуулах арга хэмжээ авахыг даалгах, тодорхой чиглэлээр аудит хийлгэхийг шаардах;

6.6.15.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх бүхий албан тушаалтныг албан тушаалаас нь чөлөөлөх, түдгэлзүүлэх, өөрчлөхийг үүрэг болгох, шийдвэрлүүлэх;

6.6.16.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн компанийн засаглалын хэрэгжилтийг үнэлэх, энэ чиглэлээрх холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж байгаа эсэхэд хяналт тавих.”

2/ “7.3.Сэндбоксын алба

7.3.1.Сэндбоксад орох, гарах хүсэлтийг хүлээн авч, холбогдох судалгаа, шинжилгээг хийж, санал боловсруулан Сэндбоксын зөвлөлд хүргүүлэх;

7.3.2.Сэндбоксад орох хүсэлтийг зөвшөөрсөн эсэхийг хүсэлт гаргагчид мэдэгдэх, холбогдох бүртгэл хөтлөх;

7.3.3.Сэндбоксын үргэлжлэх хугацаанд оролцогчдыг бүртгэх, тэдгээрийн үйл ажиллагаа зорилгодоо нийцэж буй эсэхийг хянаж, дүгнэлт гаргах, тэдгээрт байнгын зөвлөгөө өгч ажиллах;

7.3.4.Сэндбоксын хугацаа дууссаны дараа гарах төлөвлөгөөний биелэлтийг тооцох, оролцогчийн тайлан гаргах;

7.3.5.Сэндбоксад оролцогчдын үйл ажиллагаанд гарсан явцын дундах өөрчлөлтийг харгалзан журам, зааварт нэмэлт, өөрчлөлт оруулахаар санал гаргах;

7.3.6.Сэндбоксын болон нэгжийн журмыг боловсруулан батлуулах, боловсронгуй болгох санал боловсруулж, Хорооны хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлэх;

7.3.7.Сэндбоксад оролцогчдод зориулж үйл ажиллагааны заавар, зөвлөмжийг боловсруулах;

7.3.8.Сэндбоксын зөвлөлийг сэндбоксын судалгаа, мэдээлэл болон оролцогчийн сэндбоксад орох, гарахтай холбоотой шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах;

7.3.9.Ил тод байдал, хэрэглэгчийг мэдээллээр хангах үүднээс оролцогчид болон олон нийтийг холбогдох мэдээллээр хангах.”

3/ “14.ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ХЭЛТЭС

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдох салбарын стратеги бодлого, хууль тогтоомж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, мэргэжлийн холбоо, аудит хийх хуулийн этгээдийн бүртгэл, үйл ажиллагаанд мөрдөх захиргааны хэм хэмжээний актын төслийг боловсруулах, батлуулах, судалгаа шинжилгээ хийн боловсронгуй болгох, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч болон аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, үйл ажиллагааг хязгаарлах, түр зогсоох, бүртгэлээс хасах, учирч болзошгүй эрсдэлээс харилцагчийг хамгаалахад чиглэсэн үндсэн үүрэг бүхий дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

14.1.Бодлого зохицуулалтын чиглэлээр:

14.1.1.Олон улсад дагаж мөрдөгдөж буй стандартад нийцсэн өөрийн орны онцлогт тохирсон эрх зүйн орчныг бүрдүүлэх, дэмжих, хууль тогтоомжид заасан захиргааны хэм хэмжээний актын төслийг боловсруулж, батлуулах;

14.1.2.Улсын Их Хурал, Засгийн газраар хэлэлцэн шийдвэрлэх бодлогын баримт бичиг, хууль эрх зүйн актын төсөл, төрийн байгууллагууд хамтран хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, төлөвлөгөөг боловсруулах, санал дүгнэлт өгөх, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээ авах;

14.1.3.Судалгаа шинжилгээ, шаардлагатай тохиолдолд холбогдох мэдээлэл, санхүүгийн тайлангийн нэгтгэл хийж, дүгнэлт гаргах;

14.1.4.Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, өөрийн хөрөнгийн хэмжээ, зохистой харьцаа, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан судалж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах;

14.1.5.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, мэргэжлийн холбоо, аудитын хуулийн этгээдийг чадавхыг бэхжүүлэх талаар хөтөлбөр арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх;

14.1.6.Виртуал хөрөнгийн үйлчилгээ болон виртуал хөрөнгийн чиглэлээр мэргэжлийн холбоод болон бусад холбогдох байгууллагатай хамтран сургалт, семинар зохион байгуулах, хамтран ажиллах;

14.1.7.Зах зээлийн шударга, мэдээллийн нээлттэй ил тод байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх.

14.2.Бүртгэлийн чиглэлээр:

14.2.1.Бүртгэх, хязгаарлах, түр зогсоох, бүртгэлээс хасахтай холбоотой баримт, материалыг хянах, санал, дүгнэлт гаргах, танилцуулга боловсруулж, Хорооны хуралдаанаар шийдвэрлүүлэх;

14.2.2.Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, холбогдох этгээд болон эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт зэрэгтэй холбоотой баримт бичиг, хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалган дүн шинжилгээ хийж, санал дүгнэлтээ удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх;

14.2.3.Бүртгэлтэй холбоотой үйл ажиллагааг автоматжуулах, цахим шуудангаар өргөдөл, хүсэлт гаргах нөхцөлийг бүрдүүлэх, цахим үйлчилгээний оновчтой тогтолцоог бий болгож, ашиглах;

14.2.4.Бүртгэлтэй холбоотой үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, ил тод, нээлттэй байдлаар үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх;

14.2.5.Шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар холбогдох газруудаас мэргэжлийн дүгнэлт гаргуулах, лавлагаа, тайлбар авах болон бусад хэлбэрээр хамтран ажиллах;

14.2.6.Бүртгэлийн баримт бичгийн архивын нэгжийг стандартад нийцүүлж бэлтгэх, хадгалах, холбогдох нэгжид хүргүүлэх;

14.2.7.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, аудитын хуулийн этгээдийн бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж, тухай бүр мэдээллийг шинэчилж, нийтэд нээлттэй ил тод байлгах;”

ooOoo